



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНЫ ДАРГА Г.ЧИНЗОРИГ ТАНАА**

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

16160 улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бөгв 10/Бугуу-3 Хэргийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-20 42-30  
E-mail: info@audit.gov.mn

2023.03.15 № 07/560  
таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 160 дугаар тогтоолоор баталсан "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах" төслийн хүрээнд 2021-2023 онд Үндэсний радио долгионы хяналт, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын систем байгуулах, Монгол Улсын төрийн өмчийн шилэн кабелийн үндсэн сүлжээний хүртээмж, чанарыг сайжруулах арга хэмжээг хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

**Аудитын гол асуудал**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Улсын бүртгэлийн гэрчилгээгээр "Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар" гэсэн хариуцлагын хэлбэртэй, төрийн оролцоотой төсвөөс санхүүжилт авч үйл ажиллагаа явуулах статустай боловч Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь заалт, 9 дүгээр зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 4.3.2-т зааснаар хорооны жилийн төсвийг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн баталж, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгай зөвшөөрлийн орлогоос бүрдүүлэн, зарцуулдаг байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх, үүргийн талаарх заалттай нийцэхгүй, улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан хариуцлагын хэлбэр, ангиллын дагуу ажиллахгүй байна

#### **Бусад асуудлын хэсэг**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь байгууллагын стратеги төлөвлөгөөг 3-5 жилээр төлөвлөн Хорооны хуралдааны тогтоолоор батлуулж, дунд хугацааны стратегийн баримт бичигт тодорхойлсон 3 зорилтын хүрээнд нийт 274 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс байнга давтагдах шинжтэй 74 ажлаас бусад 200 арга хэмжээний гүйцэтгэлийг үнэлэхэд бүрэн хэрэгжсэн 165, Зөвшөөрлийн тухай хууль 2022 онд шинэчлэн баталснаас шалтгаалан 35 арга хэмжээг гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүссэн гэж тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

